

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 10 дугаар сарын 24

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Нийслэлээс мал гаргах ажлыг шуурхай зохион байгуулж, хотоос гаргасан малуудыг хотоос зайдуухан нэг байршилд төвлөрүүлж, тухайн төвлөрүүлсэн байршлаас малыг эзэнд нь хүлээлгэж өгөхдөө нөхөн төлбөр авах, жишиг тариф гаргах захирамжийн төслийг боловсруулж танилцуулах				
1	<p>Нийслэлээс мал гаргах ажлыг шуурхай зохион байгуулж, хотоос гаргасан малуудыг хотоос зайдуухан нэг байршилд төвлөрүүлж, тухайн төвлөрүүлсэн байршлаас малыг эзэнд нь хүлээлгэж өгөхдөө нөхөн төлбөр авах, жишиг тариф гаргах чиглэлээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд судлагдаж байна. Чингэлтэй дүүргийн хувьд:</p> <ol style="list-style-type: none">1. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсээс Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/35 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2023 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал орж ирэхээс урьдчилан сэргийлэх тухай” А/27 дугаар захирамжийн дагуу удирдамжийг батлуулж, ЗДТГ-ын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Цагдаагийн 2 хэлтсийн Зуслан дахь тасаг, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, 16-24 дүгээр хороодын Засаг даргын Ажлын албатай хамтран 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрч орж ирсэн малыг гаргах ажлыг зохион байгуулсан. Дээрх ажлын хүрээнд ажлын хэсэг 4 удаа хуралдсан ба шаардагдах 6,429,500 төгрөгийг Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлж, 12			70

	<p>өдрийн хамтарсан хяналт шалгалтаар 4690 тооны адуу малыг дүүргийн нутаг дэвсгэрээс гаргаж, 12 иргэнээс хориглосон бүсэд мал амьтан оруулахгүй байх баталгааг гаргуулан 3 иргэнд Зөрчлийн туухай хуулиар нийт 750,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч ажилласан. 2023 оны 10 дугаар сарын байдлаар дахин мал гаргах ажил зохион байгуулагдаагүй болно.</p> <p>2. Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэр нь малгүй бүс бөгөөд ногоон бүсэд орж ирсэн эзэнгүй малыг Сонгинохайрхан дүүргийн зөвшөөрөгдсөн бүс болох Гүнтийн даваагаар давуулан холбогдох эздийг тодруулж хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>3. Эзэнгүй мал нутаг дэвсгэрт орж ирсэн эсэхийг шалгах, олж тогтоох, таниулах, нутаг дэвсгэрээс гаргах, эзнийг тогтоон хүлээлгэн өгөх бүрд хүн хүч, техник хэрэгсэл, шатахуунаас эхлэн тодорхой зардал гарч байна.</p> <p>Иймд дараах зардлыг малын эздээс гаргуулах хэрэгцээ шаардлага тулгардаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Шатахууны зардлыг километр бүрээр тооцоолон гаргуулах; ✓ Малыг зөвшөөрөгдсөн цэг рүү туух үед сайн дурын иргэдийг дайчилдаг тул мал туух ажилд оролцсон иргэдийг урамшуулах цагийн хөлсийг тогтоох; ✓ Зөвшөөрөгдсөн цэгт “Журмын хашаа” барьж, малын бүрэн бүтэн байдлыг өдөр бүр хариуцан ажиллах хүн хүч, цалин хөлсийг тогтоох; ✓ Малыг анх олсноос хойш бүрэн бүтэн хүлээлгэн өгөх хүртэл хугацааны тэжээлийн зардал /өвс, ус/-ыг тус тус тогтоох зэрэг саналтай байна. 			
<p>Үүрэг даалгавар ХОЁР: Дүүргийн Засаг дарга нарт хот нийтийн аж ахуйн чиг үүргүүдийг шилжүүлэх ажлыг яаралтай танилцуулах, мөн хот нийтийн аж ахуйн тусгай зориулалтын авто машинуудын стандартыг шинэчлэх асуудлыг судалж танилцуулах</p>				
2	<p>Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трей”д ХХК-ууд 2023 онд парк шинэчлэлтээр нийт 5 хог тээврийн машин буюу 8 тонн бүхий задгай тэвштэй 3 авто машин, 3 тонн бүхий битүү гахдыг 2 авто машин нийлүүлэн ажиллаж байна. Мөн гадаадын зээл тусламжийн хүрээнд</p>			100

	байгууллага тус 3-4 хог тээврийн авто машин авах хүсэлтээ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.			
Үүрэг даалгавар ГУРАВ: Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын удирдлагууд зөвшөөрөлгүйгээр гадаадад томилолтоор ажиллахгүй байх, нийслэлээс зарласан хурал, зөвлөгөөнд орлогч нараа суулгахгүй байхад анхаарч ажиллах				
3	Нийслэлийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр гадаадад томилолтоор ажиллахгүй байх, нийслэлээс зарласан хурал, зөвлөгөөнд Засаг даргын орлогчийг суулгахгүй, өөрийн биеэр оролцоход анхаарч ажиллах чиглэлийг дүүргийн Засаг даргад танилцуулж хэрэгжилтийг ханган 2023 оны 10 дугаар сарын 16 ний хуралд оролцон цаашид харьяа газрын удирдлагуудад анхааруулж ажилласан.			
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар томоохон төсөл, хөтөлбөрүүдэд захиалагчийн хяналтын тавьдаг байх, жижиг хөрөнгө оруулалтын ажлуудын захиалагчийн хяналт тавих эрхүүдийг дүүргүүдэд шилжүүлэх, тогтолцоог судлах.				
4	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны тогтоолоор “Чингэлтэй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв” (ОНӨТҮГ)-г бий болгож, захиалагчийн хяналтыг тавих эрхийг дүрэмд тусгаж өгсөн. Үүний дагуу дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг тус төвөөр хийлгэж байна.			100
Үүрэг даалгавар ТАВ: Нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэгч байгууллагууд төсвийн орлого бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллах				
5	Дүүргийн төсөвт 2023 онд нийт 171,049.7 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 140,795.9 сая төгрөг төвлөрөхөөс 131,610.5 сая төгрөг буюу 93 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийслэлийн төсөвт 6,848.7 сая төгрөг төвлөрөхөөс 7,239.4 сая төгрөг буюу 106 хувийн гүйцэтгэлтэй. Улсын төсөвт 47,556.6 сая төгрөг төвлөрөхөөс 49,372.6 сая төгрөг төвлөрч 104 хувийн гүйцэтгэлтэй байна.			100
Үүрэг даалгавар ЗУРГАА: Орон нутгаас Улаанбаатар хот руу орж ирж байгаа автозамын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээний дагуу газраа зориулалтын бусаар ашиглаж, ажил, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авах захирамжийн төслийг яаралтай боловсруулж, гаргах.				

6	<p>Авто замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээ мөн замын трасс дагуу 5 м хүртэлх зайд газраа зориулалтын бусаар ашиглаж, ажил, үйлчилгээ эрхэлж байгаа 19 аж, ахуйн нэгж байгууллагын судалгааг Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.</p> <p>Үүнээс: 9 нэгж талбар эзэмших, 10 нэгж талбар өмчлөх эрхийн төрөлтэй байна. Хээрийн судалгааны хүрээнд 2 нэгж талбарын газар хоосон, 3 аж ахуй нэгж байгуулга зориулалтын дагуу газраа ашиглаж, 14 нэгж талбар илүү талбай хашаалж, зориулалтын бусаар ашиглаж байгаагаас 7 нэгж талбарт мэдэгдэх хуудас өгсөн.</p>			100
---	--	--	--	-----

ЗАСАГ ДАРГА
 ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ
 П.БАЯНБААТАР

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
 ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
 ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
 ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ГООМАРАЛ

НЭГТГЭСЭН:
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН

Д.БЯМБАСҮРЭН

